

**Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 12-р хуралдааны  
шийдвэрийн дагуу байгуулагдсан төрөлжсөн 3-р ажлын хэсгийн  
тайлан, дүгнэлт, зөвлөмж**

**Нэг. Ажлын хэсгийн зорилго**

Тайлагнах, нэгтгэх үйл явцыг хялбаршуулах, Засгийн газрын болон компаний тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах

**Хоёр. Хийх ажлын цар хүрээ, даалгавар**

- ОУИТБС-ын тайлангийн маягтийг дахин нягтлах
- ОУИТБС-ын тайлангийн маягт бөглөх зааварчилгааг боловсронгуй болгох
- Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессийг нягтлах, мэдээллийн найдвартай байдлыг хангах
- Аудитын нэгтгэлээр гаргаж өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах
- Компаниудын болон Засгийн газрын ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах, зөвлөмж боловсруулах

**Гурав. Бүрэлдэхүүн**

№	Албан тушаал	Нэр	Төлөөлөл	Санал болгосон
1.	Сангийн яамны НББГ-ын ахлах мэргэжилтэн	Б.Болормаа	Төр	Сангийн яам
2.	Сангийн яамны НББГ-ын ахлах мэргэжилтэн	Г.Зулай	Төр	Сангийн яам
3.	Авилгатай тэмцэх газрын УССГХ-ын ажилтан	Г.Сарангэрэл	Төр	Авилгатай тэмцэх газар
4.	Ашигт малтмалын газрын мэргэжилтэн	Г.Оюунтуяа / Н.Оюунцэцэг	Төр	Ашигт малтмалын газар

5.	Татварын ерөнхий газрын ЭБТОХ-ын улсын байцаагч	Д.Энхтуяа	Төр	Татварын ерөнхий газар
6.	Улаанбаатар аудит корпорацийн ахлах аудитор	Б.Мэндбаяр	Мэргэжлийн байгууллага	Гишүүдийн санал болгосоноор
7.	Бороо гоулд ХХК-ын татварын ахлах нягтлан бодогч	П.Болормаа	Компани	ТЕГ, Бороо гоулд
8.	Оюу толгой ХХК-ын менежер	Н.Бат-Эрдэнэ	Компани	ОТ, Бороо гоулд
9.	Байгаль эхийн аврал сан ТББ	Н.Наранцэцэг	Иргэний нийгэм	ТАН эвсэл
10.	Миний Монголын газар шороо хөдөлгөөн	Ж.Отгонсайхан	Иргэний нийгэм	ТАН эвсэл
11.	ОҮИТБС-ын АА-ын МТ зөвлөх	Г.Ганбат	Ажлын алба	Ажлын алба

### **Дөрөв. Гишүүдийн ирц, оролцоо**

Ажлын хэсэг 2015 оны 3-р сараас 6-р сар хүртэл хугацаанд ажилласан бөгөөд гишүүдээс санал авах, хэлэлцүүлэхэд зориулж Google group үүсгэн ашигласан. Дээрх хугацаанд ажлын хэсгийн хурлыг нийт 3 удаа зохион байгуулж, 54-63% ирцтэйгээр хуралдсан. Ажлын хэсгийн гишүүн Г.Сарангэрэл, Ж.Отгонсайхан нар хуралд ирээгүй, цахим шуудангаар болон бичгээр ямарч санал илэрхийлээгүй буюу ажлын хэсгийн ажилд огт оролцоогүй болно.

*Ажлын хэсгийн хуралдааны ирц*

№	Нэр	2015.03.30	2015.04.24	2015.05.22	Санал гаргасан эсэх
1	Б.Болормаа	✓	✓	✓	✓
2	Г.Зулай	✓	✓	✓	✓
3	Г.Сарангэрэл				
4	Г.Оюунтуяа Н.Оюунцэцэг			✓	✓
5	Д.Энхтуяа	✓	✓	✓	✓
6	Б.Мэндбаяр		✓		✓
7	П.Болормаа	✓	✓		✓
8	Н.Бат-Эрдэнэ	✓			✓
9	Н.Наранцэцэг		✓		✓
10	Ж.Отгонсайхан				
11	Г.Ганбат	✓	✓	✓	✓

**Тав. Даалгаварын хүрээнд хийсэн ажил**

Ажлын даалгаварын 1,2,3-р ажлын хүрээнд 2014 онд тайлан гаргасан 900 гаруй компаний 691 ажилтанд ОУИТБС-ын тайлан болон цахим тайлангийн системийн талаар 9 асуулт бүхий судалгаа илээж 130 хариу, төрийн болон орон нутгийн тайлан гаргагч 34 байгууллагын 46 ажилтанд 8 асуулт бүхий судалгаа илгээж 8 хариу хүлээн авсан<sup>1</sup>. Одоогийн маягтыг баталсанаас хойш ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудаас авч буй төлбөр, татваруудын талаар судалсан. Мөн ОУИТБС-ын тайланд анхны зөрүү үүсгэж буй нийтлэг шалтгаан, 2014 оны тайланг цахим системээр хүлээн авах үед тулгарч байсан түгээмэл асуудал зэргийг харгалзан санал, зөвлөмжийг боловсрууллаа. Маягт, түүний зааврыг боловсронгуй болгох талаар ажлын хэсгийн гишүүд нийт 15 санал<sup>2</sup> гаргаж, хэлэлцэн саналаа нэгтгэсэн.

<sup>1</sup> Судалгааны асуултууд болон үр дүн: Хавсралт 1, Хавсралт 2

<sup>2</sup> Ажлын хэсгийн гишүүдээс тайлангийн маягттай холбоотой гаргасан санал: Хавсралт 3

Ажлын даалгаварын 4-р ажлын хүрээнд ОУИТБС-ын стандарт, Улаанбаатар Аудит ХХК-ны 2013 оны нэгтгэлийн тайланг боловсруулахдаа тодруулж авсан мэдээлэл зэргийг ашиглалаа.

Даалгаварын 5-р ажлын хүрээнд ОУИТБС-ын стандартын холбогдох заалт, Засгийн газраас өргөн барьж УИХ-аар хэлэлцэж буй “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн төсөл зэргийг харьцуулж, ажлын хэсгийн гишүүдээс болон холбогдох аудитын байгууллагаас тодруулгыг авч **санал** боловсрууллаа.

### **5.1 ОУИТБС-ын тайлангийн маягтийг дахин нягтлах, маягт бөглөх зааварчилгааг боловсронгуй болгох**

Дээр дурьдсан судалгаанд оролцсон 130 компаниас 17 нь энэ жил анх удаа тайлан гаргасан бол 22 нь 5-8 удаагийн тайлан гаргасан туршлагатай байна. Мөн 71 хувь нь энэ жилийн тайлангаа гаргахад 1-3 хоног зарцуулжээ. Цахим тайлангийн систем нэвтрүүлсэнээр тайлан гаргах үйл явц өмнөхөөс илүү хялбар болсон гэж 98% нь хариулсан байна.

Судалгааны үр дүнгээс харвал компаниудын дийлэнх нь ОУИТБС-ын тайлан гаргаж байсан туршлага багатай боловч тайланг гаргахад их хугацаа зарцуулаагүй буюу хялбар байсан гэж дүгнэж болохоор байна.





Судалгаанд хамрагдсан компаниуд хамгийн ойлгомжгүй байгаа асуудлын талаар 11 санал илэрхийлсэн бөгөөд 7 нь маягттай холбоотой, 4 нь цахим тайлангийн системтэй холбоотой байна. Маягттай холбоотой саналуудыг бүлэглэж авч үзвэл:

№	Үзүүлэлт	Саналын тоо
1	Нийгмийн даатгалын шимтгэл	2
2	Үйлчилгээний хураамж	1
3	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалт, туршилтын олборлолт	2
4	Маягтын үзүүлэлт хэтэрхий их	2

Мөн ОУИТБС-ын нэгтгэлийн анхны зөрүү нь маягт ойлгомжгүйгээс болсон байх магадлалтай тул 2013 оны нэгтгэлийн тайлангаас анхны зөрүү их үүсгэсэн нийтлэг шалтгаануудыг тодруулж<sup>3</sup> маягттай холбоотой байж болох шалтгаануудыг түүвэрлэсэн.

Судалгааны үр дүн, 2013 онд анхны зөрүү үүссэн нийтлэг шалтгаан, болон 2014 оны тайлан хүлээн авах явцад тулгарч байсан нийтлэг асуудлыг авч үзвэл дараах 6 шалтгаан анхны зөрүүг нэмэгдүүлж байна.

<sup>3</sup> 2013 оны нэгтгэлийн тайлан, хуудас 84

№	Үзүүлэлт	Шалтгаан	Хүндрэл
1.	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	НДЕГ-аас хувь хүний төлсөн, ААН-ийн төлсөн дүнг ялгах боломжгүй.	Компаниуд зарим нь нийт дүн, зарим зөвхөн ААН-ын төлсөн дүнг тайлагнадаг.
2.	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, туршилтын олборлолт	Үйлдвэрлэсэн үнийн дүнд ямар дүн тайлагнах нь ойлгомжгүй	Үйлдвэрлэсэн үнийн дүн, борлуулсан үнийн дүнд ихэнх компани ижил тоо тайлагнадаг
3.	Хандив дэмжлэг	Төрийн байгууллагад төлсөн хандив дэмжлэг, сайн дурын хандив дэмжлэгийн ялгааг зарим компани ойлгодоггүй. Засгийн газар төрийн байгууллагын хүлээн авсан хандив дэмжлэгийн мэдээллийг бүрэн цуглуулж чадахгүй байна.	Төрийн байгууллагын болон бусад байгууллага, иргэдийн хүлээн авсан хандивыг хольж тайлагнаж байна.
4.	Гаалийн татвар	Гаалийн татвар, НӨАТ, Гаалийн үйлчилгээний хураамжийг Гаалийн ерөнхий газарт төлдөг тул нэг төлбөр гэж боддог.	Гаалийн татварт бөөн дүнгээр тайлагнадагаас болж зөрүү үүсдэг.
5	Орон нутгийн төсөвт төлсөн төлбөр, торгууль	Засгийн газар орон нутагт хүлээн авсан төлбөр торгуулын	Анхны зөрүүний нэг шалтгаан болдог

		мэдээллийг бүрэн цуглуулж чадахгүй байна.	
6	Тайлангийн мөнгөн дүнг МЯНГАН төгрөгөөр тайлагнах	Санхүүгийн тайлан, татварын тайлан гэх мэт тайлан МЯНГАН төгрөгөөр авахаа больсон. Төрийн байгууллагын мэдээллийн сангуудад мэдээлэл нь төгрөгөөр хадгалагдаж байдаг.	Зарим компаниуд болон төрийн зарим байгууллага төгрөгөөр тайлагнах явдал гарч байна. Систем мөнгөн дүнгээ мянгачилсан эсэхийг шалгах боломжгүй.

Дээрх үндэслэл, судалгаанд оролцсон компаниуд болон ажлын хэсгийн гишүүдийн саналыг үндэслэн ОУИТБС-ын тайлангийн маягтууд, түүний зааварт дараах<sup>4</sup> өөрчлөлтүүдийг оруулахыг санал болгож байна.

---

<sup>4</sup> Маягтын шинэчилсэн хувилбарыг хавсралт ..., зааврын шинэчилсэн хувилбарыг хавсралт ... ээс тус тус харна уу

#	Маягт	Маягтын үзүүлэлт	Одоогийн байдал	Оруулах өөрчлөлт	Үндэслэл, тайлбар
1	4,5,6	Тайлан гаргах хугацаа	Маягт 4, 5: 2-р сарын 15 Маягт 6: 4-р сарын 30	Маягт 4, 5: 3-р сарын 31 Маягт 6: 4-р сарын 30	Нэгтгэлийг ажлын алба гаргах
2	1,2,3	Тайлан гаргах хугацаа	Бүгд 2-р сарын 15	Бүгдийг 3-р сарын 31	
3	4,5,6	Бусад 1.6.4		Хасах	Юуг тусгах болон тусгасан нь мэдэгдэхгүй тодорхойгүй үзүүлэлт нь тайлангийн зөрүүг нэмэгдүүлдэг.
4	1,2,3,4	Усны бохирдлын төлбөр	Одоо байхгүй	Нэмэх	2012 онд батлагдсан “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийн дагуу <a href="http://www.legalinfo.mn/law/details/8684">http://www.legalinfo.mn/law/details/8684</a>
5	Бүх маягт	Хувь хүний орлогын албан татвар	Одоо байхгүй	Сайн дурын мэдээлэлд нэмэх	Компаний төлж буй татвар биш боловч уул уурхайн салбартай холбоотойгоор бий болж буй татварын орлого тул
6	7	Тайлан гаргах хугацаа	3-р сарын 15	7-р сарын 1	Тайланг мэргэжилтэнүүд хянаж дуусах хугацаа болоогүй. Нөөц тулгахаас эхлээд ажил их ордог
7	1, 2	Маягт нэгтгэх		1,2 -р маягтийг нэгтгэх	Үзүүлэлтийн хувьд бараг ялгаагүй 2 маягт байгаа. Маягтын тоог нэмэгдүүлдэг, компаниудад ойлгомжгүй байдал үүсдэг
8	1,2,3	Хянасан аудиторын гарын үсэг	Гарын үсэг шаарддаг	Удирдлагын хариуцлагын захидал, Аудитлагдсан тайлан, дүгнэлтийг хавсаргав	
9	Бүх маягт	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын нөхөн төлбөр	Бүх маягтад байгаа	Хасах	Татвар нь хүчингүй болсон
10	5	Төрийн байгууллагын бөглөх боломжгүй сайн дурын мэдээллүүд	5-р маягтад байгаа	Хасах	Төрийн байгууллага мэдэх, бөглөх бололцоогүй
11	3, 5,6	Газрын тосны компаниудын байршуулдаг барьцаа 3%	Одоо байхгүй	Нэмэх	Газрын тосны тухай хуулийн 11.2.9 <a href="http://www.legalinfo.mn/law/details/10484?lawid=10484">http://www.legalinfo.mn/law/details/10484?lawid=10484</a> <sup>5</sup>
12	Бүх маягт	Мянган төгрөг	Бүх маягт	Мянгачилахаа болих	
13	1,2,3	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалт	Үйлдвэрлэсэн үнийн дүн	Үйлдвэрлэсэн зардал	

<sup>5</sup> ... байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах



14	1,2,3	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуултын мэдээлэл	Нэгдсэн дүнгээр авдаг	Лиценз тус бүрээр авах	
14	1,2,3	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	Нэгдсэн дүнгээр авдаг	Лиценз тус бүрээр авах	
15	1,2,3	АМНАТ болон нэмэлт төлбөр	Нэгдсэн дүнгээр авдаг	Лиценз тус бүрээр авах	
16	1,2,3	Орон нутгийн төсөвт төлсөн төлбөр хураамж	12 төлбөр тус бүрийг нэгдсэн дүнгээр авдаг	12 төлбөр тус бүрийг төлсөн аймаг, дүүрэг, хотоор авах	
17	1,2,3,4,5	Төрийн байгууллагад төлсөн хандив дэмжлэг	Нэгдсэн дүнгээр авдаг	Хандив тус бүрээр авах	
18	1,2,3	Сайн дурын хандив дэмжлэг	Нэгдсэн дүнгээр авдаг	Хандив тус бүрээр авах	

## **5.2 Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессийг нягтлах, мэдээллийн найдвартай байдлыг хангах**

Төрийн байгууллагуудаас авсан судалгаанд 8 байгууллага хариулсан бөгөөд маягттай холбоотой 1 санал ирсэн.

Төрийн байгууллагын мэдээлэл цуглуулах процессийн хувьд судалгаанд оролцсон ихэнх байгууллага цаасан мэдээлэл болон файлаас тайлангийн мэдээллээ шүүж боловсруулсан бол 2 байгууллага өөрийн мэдээллийн системээс мэдээллээ татаж авч тайлангаа бэлтгэсэн. Аймаг дүүргүүдийн санхүү төрийн сангийн хэлтэс, татварын хэлтэс хамтарч тайлан гаргадаг бөгөөд зарим аймагт тайлангаа хэн бэлтгэх, илгээх талаар зөрчил үүссэн байна.

Төрийн ихэнх байгууллага цаасан мэдээлэл болон файлаас тоон мэдээллүүд шүүж тайлан бэлтгэж байгаа нь хувь хүнээс хамаарсан энгийн алдаа гарах магадлалыг нэмэгдүүлж байна.

**Аймгийн засаг даргын тамгын газрын Төрийн сангийн хэлтэс орон нутгийн тайлангаа нэгтгэж гаргахаар зохицуулах саналтай байна.**

Үүнээс гадна төрийн байгууллага өөрийн хүлээн авсан орлогоо тайлагнах ёстой атал Төрийн өмчийн хорооноос Эрдэнэт, Монголросцветмэт компаниудад тайлан гаргана уу гэсэн утгатай албан бичиг илгээсэн байсан.

## **5.3 Аудитын нэгтгэлээр гаргаж өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах**

Стандартын 3-р шаардлагад ОУИТБС-ын тайланд оруулах ёстой мэдээллүүдийг тодорхой заасан. Эдгээр нь:

№	Мэдээлэл	ОУИТБС-ын стандартын шаардлага
1	Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт, төсвийн бодлогын талаарх тодорхой мэдээлэл ялангуяа ОУИТБС-ын тайланд тайлагнадаг мэдээлэлтэй холбоотой хуулиуд	Шаардлага 3.2

2	Тухайн жилд хийгдсэн томоохон хэмжээний хайгуулын үйл ажиллагаа гэх мэт олборлох салбарын талаарх тойм мэдээлэл	Шаардлага 3.3
3	Тухайн тайлант жилд олборлох салбараас эдийн засагт оруулсан хувь нэмрийн талаар (үйлдвэрлэл, орлого, ажлын байр, гол бүс нутаг)	Шаардлага 3.4
4	Тухайн тайлант жилийн үйлдвэрлэлийн мэдээ	Шаардлага 3.5
5	Олборлох салбарт оролцож буй төрийн оролцооны талаар мэдээлэл	Шаардлага 3.6
6	Олборлох салбараас олж буй орлогын хуваарилалтыг тайлбарлах	Шаардлага 3.7
7	ОТАХ-ээс орлогын менежмент, зарцуулалтын талаар хүсэлт тавьсан нэмэлт мэдээлэл	Шаардлага 3.8
8	Лицензийн бүртгэл	Шаардлага 3.9
9	Лиценз олголт	Шаардлага 3.10
10	Бенефициар өмчлөгч	Шаардлага 3.11
11	Гэрээ	Шаардлага 3.12

Эдгээрээс ОУИТБС-ын шаардлага 3.4, 3.5 –ын дийлэнх мэдээллийг тайлангийн маягтын дагуу хүлээн авдаг бол бусад мэдээллүүдийг аудитын нэгтгэлийн үед компани, холбогдох төрийн захиргааны байгууллага, болон бусад эх сурвалжаас нэмэлтээр авч байна. 2013 оны нэгтгэл тайлангийн үед Улаанбаатар Аудит компаниас АМГ-т хандаж дараах мэдээллүүдийг хүссэн байна.

- Лицензийн бүртгэл
- Лицензийн хөдөлгөөний бүртгэл
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа
- Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа
- Хөрөнгө оруулалтын талаархи судалгаа
- Уурхайн бүтээгдэхүүн борлуулалтын тайлан

- Хайгуулын үйл ажиллагаа
- Нийт үйлдвэрлэл
- Нийт экспорт
- Лиценз олголт
- Хуулийн талаар
- Бусад

Мөн тулган баталгаажуулалтад хамрагдсан компаниудаас дараах мэдээллийг хүссэн байна.

- Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
- Төрийн байгууллагад төлсөн төлбөрийн дэлгэрэнгүй
- Аймгийн ЗДТГ-тай хийсэн гэрээний судалгаа
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэгжилт
- Ажиллагсадын судалгаа
- ТУЗ-ын талаар судалгаа
- Ногдол ашиг

### **Санал, зөвлөмж**

Нэмэлтээр авч буй мэдээллүүдээс ажиллах хүч, бенефициар эзэд, тусгай зөвшөөрлийн олголт, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн мэдээлэл, үйлдвэрлэлийн мэдээлэл зэргийг тодорхой маягтад оруулах боломжтой бөгөөд ач холбогдолтой гэж үзэж байна. Нэмэлт мэдээллийн маягтыг хавсралтаас харна уу.

Харин тайлангийн зөрүү шийдвэрлэхтэй холбоотой шаардсан мэдээллүүд нь компани, төрийн байгууллага нэг бүрийн хувьд харилцан адилгүй тул нэгдсэн маягтад оруулах боломжгүй байна.

### **5.4 Компаниудын болон Засгийн газрын ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах, зөвлөмж боловсруулах**

Тайлан гаргаж буй компаниудын болон Засгийн газрын ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах асуудлын талаар ОУИТБС-ын стандартын 5.2-т дараах байдлаар тусгасан байна.

.... Хараат бус аудитор, олон талын оролцоот бүлгийн зүгээс шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд дараах баталгаажуулалтын хувилбарууд байж болно.

- Тайлан гаргаж буй компани, төрийн байгууллагын өндөр албан тушаалтан нь бүрэн бөглөсөн тайлангийн маягт дээр тухайн өгсөн мэдээлэл нь бүрэн, үнэн зөв болохыг батлан гарын үсгээ зурах.
- Компаниуд нь тухайн гарган өгсөн мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан дээр үндэслэсэн болохыг баталгаажуулсан өөрийн аудитын компаниас олгосон баталгаажуулалтын захидлыг тайландаа хавсаргах. Олон талын ажлын хэсэг нь ийм төрлийн үйл явцыг тодорхой үе шаттайгаар хийх хүсэлтэй байж болох бөгөөд ингэснээр баталгаажилтын захидлыг тухайн компаний сонгон авсан аудиторын үйл ажиллагааны нэгэн хэсэг болгох зорилготой байж болно. Зарим компаниудын хувьд хуулийн дагуу заавал хараат бус аудит хийлгэхийг шаарддаггүй байж болох тул тэдгээр компани нь дээр дурдсан баталгаажилтын захидлыг гарган өгөх боломжгүй байх тухай тодорхой дурдан, энэ асуудлыг шийдэхийн тулд хийгдэж буй эсвэл төлөвлөж буй арга хэмжээний тухай тайланд мэдээлэх ёстой.
- Хэрэв боломжтой бол тайлан гаргаж буй төрийн байгууллагууд нь өөрийн аудитын байгууллагаас эсвэл ижил төстэй байгууллагаас тайланд өгсөн мэдээлэл нь үнэн зөв болох баталгаажуулалтыг өгч болно.

Мөн Засгийн газраас УИХ-д өргөн барьж хэлэлцүүлж буй “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн төслийн 11.7, 11.8, 12.7, 12.9-д ОУИТБС-ын анхан шатны тайлан болон түүний баталгаажилтын талаар тусгасан байна<sup>6</sup>. Эдгээр нь:

*11.7 ... тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь анхан шатны тайланг аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн гаргана.*

---

<sup>6</sup> Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл

11.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд анхан шатны тайланд туссан мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

12.7. Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.

12.9. Төрийн байгууллагын тайлан гаргагч бүр тус бүрийн гаргасан ил тод байдлын тайланд туссан мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

Компаниудын ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах талаар ажлын хэсэгт багтсан компаниудаас дараах саналыг илэрхийлсэн.

1. Аудитын үйлчилгээний үнэлгээ нь баталгаажуулж буй ажлын үнийн дүнтэй шууд хамааралтай байдаг тул компаниудад аудитын үйлчилгээний нэмэлт зардал гаргах зэрэг санхүүгийн дарамт учруулдаг. Энэ нь зөвхөн компаниудад ч гэлтгүй цаашлаад улс орны эдийн засагт ч үр ашиггүй зардал болон татварын орлого буурахад нөлөөлж болзошгүй.

2. Уг тайлангийн мөнгөн төлбөрөөс бусад үзүүлэлтүүд компанийн санхүүгийн аудитлагдаж буй дүнтэй уялдан гардаг учир онол болон практикийн хувьд аудитаар баталгаажуулах хэрэгцээгүй.

3. Уг тайланг бэлтгэх, тушаах хугацаа нь компанийн санхүүгийн болон татварын жилийн эцсийн тайлан бэлтгэхтэй давхацдаг, санхүүгийн тайлангийнхаа аудитын дүгнэлтийг авч амжаагүй (практик дээр томоохон компаниудын аудитлагдсан тайлан 3-р сарын 31-тэй зэрэгцэн гардаг) үед гардаг учир тусгайлсан аудитын багтай хамтарч ажиллах, шалгуулах цаг хугацаа болон хүн хүчний боломж байдаггүй.

4. Уг тайлангийн мөнгөн төлбөрүүдийн жагсаалт нь компанийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн чанар, үйл ажиллагаа, санхүүгийн мэргэжилтний нягт нямбай байдал, ур чадвартай шууд холбоотой байдаг тул үүнийг заавал аудитаар шалган баталгаажуулах нь тайлангийн үр дүнд нөлөөлөхүйц хэмжээний ач холбогдол өгөхгүй.

ОҮИТБС-ын стандартад байж болох баталгаажуулалтын хувилбаруудыг санал болгосон бөгөөд Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг боломжит хувилбаруудаас сонголт хийж болохоор байна.

Одоо хэлэлцэж буй Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд анхан шатны тайланг аудитаар баталгаажуулахгүйгээр, аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн гаргахаар тусгасан байна.

Компаниудын ОҮИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах нь ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүдэд нэмэлт дарамт учруулахаар байна.